

НЭГ. ЕРӨНХИЙ ХЭСЭГ

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл 12 удаа хуралдаж, 37 асуудал хэлэлцэн 57 тогтоол гарган, хуралдааны тэмдэглэлийг албажуулан ажилласан.

Төрийн албаны зөвлөлийн Хэнтий аймаг дахь салбар зөвлөл нь 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 21 арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомж, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журмын хүрээнд ажил үүргийн хуваарь гарган хэрэгжүүлэн ажиллалаа.

ХОЁР. ҮНДСЭН ХЭСЭГ

2.1. Төрийн албаны тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1 дэх хэсэг:

74.1.1.төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалт болон төрийн албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн эрх зөрчигдсөн маргааныг хянан шийдвэрлэсэн дүн;

Төрийн албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн эрх зөрчигдсөн маргаан гараагүй болно.

74.1.2.төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилт, зөрчлийн талаархи дүгнэлт, цаашид авах арга хэмжээний санал;

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн хэрэгжилтийг хангах ажлыг орон нутгийн хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс 2020 оны 01 дүгээр сард аймгийн Ардын дуу бүжгийн “Хан Хэнтий” чуулгын ажилчдад /42/ Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүй, Хөдөлмөрийн тухай хуулиар сургалт зохион байгуулсан. Цахимаар 8 удаагийн сургалтад 150 төрийн албан хаагч хамрагдсан.

2020 оны 9 дүгээр сарын 10, 11-ний өдөр Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Төрийн албаны шинэтгэл, ёс зүйн хандлага” сэдэвт ёс зүйн зөвлөлийн нэгдсэн зөвлөгөөнд аймгийн Засаг даргын Тамгын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Нэгдсэн эмнэлэг, Ерөнхий боловсролын сургуулиас төлөөллүүд биечлэн, 118 төрийн байгууллагын ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүн цахимаар оролцсон. Тус зөвлөгөөнд хэлэлцсэн асуудлын талаар зөвлөгөөнд оролцогчид байгууллагынхаа албан хаагчдад мэдээлэл хүргэж ажилласан.

Төрийн албаны зөвлөлийн 2020 оны “Төрийн албанд ёс зүй, сахилга, хариуцлагыг сайжруулах тухай” 02 дугаар зөвлөмжийг агентлаг, байгууллагуудад хүргүүлэн тус зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.



Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн зөрчлийн 2020 оны мэдээгээр төрийн захиргааны 2 албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан талаар гомдол ирснийг шалгаж ёс зүйн зөрчил гаргаагүй гэж үзэж, төрийн тусгай 9, үйлчилгээний 18 албан хаагч зөрчил гарган хариуцлага тооцсон байна.

Санал: Ёс зүйн зөрчлийн мэдээ, тайлангаас харахад төрийн үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн талаарх мэдлэгийг дээшлүүлэх тал дээр анхаарч ажиллах шаардлагатай байна.

74.1.3.төрийн албаны тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал;

1. Төрийн албаны ерөнхий шалгалт өгч эхний 1-2 шалгалтад босго оноог даваад дараагийн шалгалтуудад босго оноог давж чадаагүй тохиолдолд тухайн иргэнийг дахин зарлагдах Төрийн албаны ерөнхий шалгалтад босго оноог давсан шалгалтыг тооцож, унасан шалгалтуудыг өгөх боломжийг хангах

2. Туслах түшмэлийн ангиллын албан тушаалд томилогдох иргэнийг албан тушаалын тусгай шаардлагыг хангаж байгаа тохиолдолд Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн шийдвэрээр төрийн албаны тусгай шалгалтгүйгээр төрийн жинхэнэ албаны нөөцөөс нэр дэвшүүлэн томилох

3. Төрийн захиргааны удирдах албан тушаалын сонгон шалгаруулалтыг босго оноотой болгох /нийт дүнгээр босго заах/

4. Байгууллага, нэгж дотор, нэгжээс нэгжийн хооронд шилжүүлэн томилох тохиолдолд зохицуулалт байхгүй байгааг шийдвэрлэх

5. Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журмын 2.5.4-т заасныг зөвхөн 50 хувийг хангаж байгаа албан хаагч гэж хязгаарлахгүйгээр нийт шатлан дэвших албан хаагчид тавих шаардлага болгож оруулах, мөн өөр байгууллагаас шатлан дэвшүүлэх тохиолдолд энэхүү заалтыг хэрхэн шийдвэрлэх талаар тодорхой болгох

6. Төрийн албан хаагчдын ёс зүйн дүрэмд хариуцлага хүлээлгэх уучлал гуйхыг үүрэг болгох, сануулах гэсэн 2 хариуцлага хүлээхээр заасан. Үүнийг Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан арга хэмжээгээр хариуцлага хүлээлгэх

74.1.4.мэдлэг, ур чадвар, туршлагад суурилсан, улс төрөөс хараат бус, шударга, ил тод, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлэх, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааны талаар цаашид авах арга хэмжээний санал.

Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг сайжруулах зорилгоор 2020 оны 8 дугаар сарын 21-ний өдөр 185 төсвийн шууд захирагч, 18 сумын ИТХ-ын дарга, Засаг дарга, 5 тосгоны захирагч, аймгийн удирдлагуудыг оролцуулан нийт 250 гаруй удирдах албан хаагчдын “Аймгийн удирдах ажилтны зөвлөгөөн”-ийг жил бүр зохион байгуулж хэвшүүлээд байна.

Санал:

1. Төрийн захиргааны албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлэх,
2. Хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцны зээлд хамруулах,
3. Чухал шаардлагатай мэргэжлээр хөдөө, орон нутагт ажиллаж байгаа албан хаагчдыг орон байраар хангах,
4. Төрийн захиргааны албан тушаалд хөдөө, суманд ажиллаж байгаа болон аймгийн төвийн хүний нөөц дутмаг байгаа салбарт ажиллаж байгаа албан хаагчдад орон нутагт ажилласан нэмэгдлийг 5 жил тутамд олгох /тухайлбал: Эрүүл мэндийн газар/

5. Аймгийн төвийн сумын Засаг даргын Тамгын газарт ажиллаж буй төрийн захиргааны албан хаагчдын, мөн аймгийн Засаг даргын тамгын газар, агентлагийн албан хаагчдын ангилал, зэрэглэлийг нэмэгдүүлэх

2.2. Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам:

1. Зохион байгуулалтын хүрээнд:

1.1. Төрийн албаны шинэтгэл, Төрийн албаны тухай хууль тогтоомж, бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, энэ талаар харьяалах байгууллагад мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгөх;

Төрийн албаны тухай хууль 2019 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж, Төрийн албаны тухай хууль, төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд батлагдан гарсан дүрэм, журмыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төрийн албатай холбоотой хууль, тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, заавар, журмын талаар зөвлөгөөг тухай бүрд нь өгч ажиллаж байна.

Агентлаг, байгууллагын дарга нарын шуурхай зөвлөгөөнийг 7 хоног бүрийн даваа гарагийн 16:00 цагт хийж хэвшсэн бөгөөд хорио цээрийн дэглэмийн үед цахим хэлбэрээр мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулж байна.

Төрийн албаны шинэтгэл, Төрийн албаны тухай хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн талаар сумдын Засаг даргын Тамгын газрын албан хаагчидтай 1 удаагийн цахим сургалт, агентлаг, байгууллагуудын албан хаагчдад 2 удаагийн цахим сургалт зохион байгууллаа.

1.2. Төрийн байгууллагын чиг үүргийн шинжилгээ хийх ажлыг Төрийн албаны зөвлөлөөс баталсан заавар, аргачлалын хүрээнд зохион байгуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөөг өгөх;

Засгийн газрын “Төвлөрлийг сааруулах талаар төрөөс баримтлах бодлого” 2016 оны 350 дугаар тогтоол, Засгийн газрын “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал батлах тухай” 2018 оны 22 дугаар тогтоолын хүрээнд чиг үүргийн шинжилгээ хийж ажилласан.

Чиг үүргийн шинжилгээг Байгаль орчин, аялал жуулчлалын албан хаагч тус бүрээр давхардал хийдэл байгаа эсэхийг нягталж албан хаагчдын ачааллыг тэнцвэржүүлэн албан тушаалын гүйцэтгэх чиг үүргүүдийг шинэчлэн аймгийн Засаг даргын 2020 оны “Бүтэц, дүрэм батлах тухай” А/04 дүгээр захирамжаар тус газрын бүтэц, орон тоог шинэчлэн баталсан.

Бүтэц орон тооны шинэчлэлээр Хэнтий аймаг аялал жуулчлалын бүс нутагтай холбоотой Аялал жуулчлалын алба байгуулахаар шийдвэрлэсний дагуу Аялал жуулчлалын албаны 3 албан тушаалтны албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын дагуу боловсруулан журамд заасны дагуу холбогдох баримт бичгийн хамтаар Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Аялал жуулчлалын албаны даргын албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 77 дугаар тогтоолоор батлах зөвшөөрлийг олгосон.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоонд чиг үүргийн шинжилгээг хийж шинэчлэн батлуулах саналыг боловсруулан Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөлд тус тус хүргүүлэн ажилласан.

1.3. Төрийн албаны зөвлөлийн Ажлын албанд тайлан, мэдээг тогтоосон хугацаанд хүргүүлэх;

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2019 оны жилийн эцсийн тайланг 2020 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 02 тоот албан бичгээр, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн зөрчлийн мэдээг хагас, бүтэн жилээр гаргаж хүргүүлсэн.

Мөн төрийн албан хаагчидтай холбоотой судалгаа, мэдээг хугацаанд нь гаргаж хүргүүлэн ажилласан.

1.4. Салбар зөвлөлийн эрх хэмжээний хүрээнд шийдвэр гаргах, шийдвэрийн биелэлтийг хангуулах;

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл 12 удаа хуралдаж, 37 асуудал хэлэлцэн 57 тогтоол гарган, хуралдааны тэмдэглэлийг албажуулан ажиллаж байна. /ирсэн бичиг 158, явсан бичиг 114/

Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэр, шийдвэрийн хэрэгжилт тооцсон байдлыг хавсралтаар үзүүлэв.

2. Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх хүрээнд:

2.1. Харьалах байгууллагын “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцооны цахим систем”-д тухай бүр мэдээлэл оруулах;

Хүний нөөцийн нэгдсэн системд Хэнтий аймгийн 188 байгууллагын мэдээллийг оруулах ажлыг шуурхай, хугацаанд нь зохион байгуулсан.

Мөн Хүний нөөцийн нэгдсэн системтэй цалингийн нэгдсэн систем холбох ажлын хүрээнд байгууллагын холбогдох албан тушаалтныг сургалтад хамруулан мэдээллийг шинэчлэх, залруулах ажлыг бүрэн гүйцэтгэсэн.

2.2. Төрийн байгууллагыг төрийн албан хаагчийн тоо бүртгэл хөтлөхөд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

Хүний нөөцийн системд бүртгэл хөтлөхөд гарч буй саад, бэрхшээлийн талаар тухай бүр нь арга хэмжээг авч, арга зүйн удирдлагаар хангаж ажилласнаар цалингийн нэгдсэн системтэй холбох ажиллагаа амжилттай хийгдсэн.

Агентлаг, байгууллагуудад 2020 оны 12 дугаар сарын 31-ний дотор мэдээллийг нягталж, бүрэн оруулах ажлыг зохион байгуулах талаар чиглэл хүргүүлэн ажиллав.

3. Төрийн албаны нөөц бүрдүүлэх хүрээнд:

3.1. Харьалах байгууллагын хүний нөөцийн бүртгэл, хөдөлгөөнийг “Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам”-д заасны дагуу хийх;

Төрийн жинхэнэ албан тушаал эрхэлж байгаа албан хаагчийн нөөцийн бүртгэл, төрийн жинхэнэ албаны ерөнхий шалгалт өгч тэнцсэн иргэний нөөцийн бүртгэл, төрийн жинхэнэ албанаас чөлөөлөгдсөн албан хаагчийн болон иргэний нөөцийн бүртгэлийг “Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам”-ын дагуу хийж гүйцэтгэн Төрийн албаны зөвлөлд тухай бүрд нь хүргүүлж ажилласан.

Төрийн жинхэнэ албанд ажиллаж байгаад хуульд зааснаар төрийн албаны нөөцөд бүртгүүлэхээр 10 иргэн хүсэлтээ ирүүлснийг бүртгэж авсан.

3.2. Төрийн байгууллага, албан хаагч, иргэдийг нөөцийн санд хамаарах мэдээллээр хангах, энэ талаар бүртгэл хөтлөх;

Төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцийн сангаас мэдээлэл, хүсэлт авахыг хүссэн 8 байгууллагад нөөцийн санд хамаарах мэдээллээр ханган, бүртгэл хөтлөн ажилласан.

Төрийн жинхэнэ албаны нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн 9 иргэнд нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн болохыг тодорхойлох баримт бичгийг олгосон.

4. Маргаан хянан шалгах хүрээнд:

4.1. Маргаан хянан шалгах комиссын үүрэг даалгаврын дагуу асуудлыг шалгах, холбогдох баримт, материалыг бүрдүүлэх, холбогдох этгээдээс тайлбар, тодорхойлолт авах;

Салбар зөвлөлд 11 өргөдөл, гомдол ирснийг 2 өргөдлийг Төрийн албаны зөвлөлд шилжүүлэн ажилласан.

Бор-Өндөр сумын Газрын даамал Т.Эрдэнэзаяагийн “Сануулах сахилгын шийтгэл ногдуулсныг хүлээн зөвшөөрөхгүй шалгуулах” тухай, Аймгийн засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн ахлах мэрэгжилтэн Ж.Ганбаярын “Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах боломж олгоогүй, төрийн албаны тусгай шалгалтад бүртгээгүй” тухай өргөдлийг тус тус Төрийн албаны зөвлөлд шилжүүлсэн.

Монгол Ардын намаас “Төрийн албан хаагч сонгуулийн сурталчилгаанд оролцсон” тухай, 5 иргэнээс “Төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгүүлэх” тухай, 2 иргэнээс “Нөөцөд бүртгэлтэй талаар тодорхойлолт гаргуулах” тухай, 1 иргэнээс “Төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэлтэй эсэх талаар тодруулах” тухай өргөдөл, гомдол ирсэн.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хурлаар ирсэн өргөдлийг хэлэлцүүлэн /аймгийн Засаг даргад хандан гаргасан өргөдөлд Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагаа, сонгон шалгаруулалттай холбоотой асуудал дурдагдсан тул салбар зөвлөлд холбогдох хэсгийг тодруулж өгөх талаар хүсэлтийг Нийгмийн бодлогын хэлтсээс ирүүлсэн/ тодруулга өгөх ажлын хэсгийг томилон шийдвэрлүүлж, тус өргөдөлд холбогдох тодруулгыг хүргүүлсэн.

УИХ-ын сонгуулийн сурталчилгаанд төрийн албан хаагч оролцсон талаар ирүүлсэн гомдлын дагуу тухайн албан хаагчтай холбоотой мэдээллийг цуглуулж төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэсэн.

4.2. Зөвлөлийн шийдвэрээр маргаан хянан шалгах комиссын бүрэлдэхүүнд ажиллуулах;

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2020 оны 10 дугаар тогтоолоор гомдлын дагуу тодруулга өгөх ажлын хэсэг томилон ажиллуулсан.

4.3. Төрийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргах санал Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх, энэ талаар зохих арга хэмжээ авах;

Төрийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргах шаардлага гараагүй.

5. Төрийн албаны шалгалт зохион байгуулах хүрээнд:

5.1. “Төрийн албаны ерөнхий шалгалт өгөх болзол, журам”, “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-д заасны дагуу шалгалт зохион байгуулах;

Хэнтий аймгийн хэмжээнд төрийн албанд гарсан сул орон тооны захиалгыг хүлээн авч, хянан нийтэд нээлттэй сонгон шалгаруулалтыг зарлуулахаар 162 сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлд тухай бүр нь албан бичгээр хүргүүлсэн.

Үүнээс төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагчийн 24, төрийн жинхэнэ албан тушаалын удирдах 16, гүйцэтгэх 138 сул орон тооны захиалга Төрийн албаны зөвлөлийн сайтад 2020 оны 4-12 дугаар саруудад нийтэд нээлттэй зарлагдаж сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан.

11 удаагийн сонгон шалгаруулалтад нийт 178 албан тушаалд давхардсан тоогоор 86 иргэн бүртгүүлж, тавигдах шаардлагыг хангасан 64 иргэн шалгалт өгч, 45 иргэн тэнцсэн.

Төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагчийн 17, төрийн жинхэнэ албан тушаалын удирдах 8, гүйцэтгэх 16 сул орон тоо нөхөгдөөд байна.

Сонгон шалгаруулалтын дүн мэдээг тухай бүр нь Төрийн албаны зөвлөлд хүргүүлэн ажиллаж байна.

Төрийн албаны ерөнхий шалгалтыг 2020 оны 11 дүгээр сарын 06-08-ны өдрүүдэд зохион байгуулсан. Төрийн албаны ерөнхий шалгалтад 324 иргэн бүртгүүлж, 226 иргэн шалгалтад орсноос ерөнхий мэдлэгийн шалгалтад 45, монгол хэл, бичгийн шалгалтад 34, дүн шинжилгээ хийх чадварын шалгалтад 32 иргэн тус тус тэнцэж, төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдсэн.

5.2. Сонгон шалгаруулалт явуулах захиалгыг хүлээн авах, хянах, зарлуулах;

Хэнтий аймгийн хэмжээнд төрийн албанд гарсан сул орон тооны захиалгыг хүлээн авч, хянан нийтэд нээлттэй сонгон шалгаруулалтыг зарлуулахаар 162 сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлд тухай бүр нь албан бичгээр хүргүүлсэн.


Үүнээс төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагчийн 14, төрийн жинхэнэ албан тушаалын удирдах 11, гүйцэтгэх 127 сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлийн сайтад 2020 оны 4-6 дугаар саруудад 11 удаа нийтэд нээлттэй зарлагдаж сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан.

5.3. Шалгалтын комисс байгуулах;

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2020 оны 03 дугаар тогтоолоор төрийн албаны тусгай шалгалтыг зохион байгуулахад шалгалтын комиссод дэмжлэг үзүүлэх шалгалтын зөвлөлийг байгуулсан.

Төрийн албаны ерөнхий шалгалтыг зохион байгуулах салбар комиссыг 49 дүгээр, төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтын комиссыг 04, 11, 34, 50 дугаар, төрийн албаны тусгай шалгалтын комиссын бүрэлдэхүүнийг 05, 09, 20, 22, 30, 31, 51 дүгээр тогтоолоор тус тус байгуулсан.

Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 141 дүгээр тогтоол, түүнийг хэрэгжүүлэх аргачлалын дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан бөгөөд хорио цээрийн дэглэмийн хүрээнд Улсын онцгой комиссын шийдвэр, Эрүүл мэндийн яамны зөвлөмжийг мөрдөж ариутгал халдваргүйтгэл, шалгалтад оролцогчдын халууныг зайнаас хэмжих, дэглэмийг мөрдүүлэх зэрэг үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж ажиллав.



5.4. Албан тушаалын сул орон тоонд зохих журмын дагуу нэр дэвшүүлэх;

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн дагуу Төрийн албаны тусгай шалгалт өгч хамгийн өндөр оноо авсан иргэдийг тухайн албан тушаалд нь нэр дэвшүүлэх салбар зөвлөлийн 41 тогтоолыг гаргасан.

11 удаагийн сонгон шалгаруулалтад нийт 178 албан тушаалд давхардсан тоогоор 86 иргэн бүртгүүлж, тавигдах шаардлагыг хангасан 64 иргэн шалгалт өгч, 45 иргэн тэнцэж, төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагчийн 17, төрийн жинхэнэ албан тушаалын удирдах 8, гүйцэтгэх 16 сул орон тоо нөхөгдөөд байна.

Сонгон шалгаруулалтын дүн мэдээг тухай бүрд нь Төрийн албаны зөвлөлд хүргүүлэн ажиллаж байна.

5.5. Нэр дэвшүүлсэн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;

41 сул орон тоонд нэр дэвшүүлсэн бөгөөд нэр дэвшүүлсэн 41 иргэнээс 39 нь томиогдож, шийдвэрийн хэрэгжилт 95,1 хувьтай байна.

6. Хяналт тавих, аудит хийх хүрээнд:

6.1. Харьяалах төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүний нөөцийн аудитыг Төрийн албаны зөвлөлөөс баталсан аргачлал, удирдамжийн дагуу хийх;

Аргачлал, удирдамж ирээгүй.

6.2. Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд Төрийн албаны зөвлөлөөс баталсан аргачлал, удирдамжийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

Аргачлал, удирдамж ирээгүй.

6.3. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих;

Аймгийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлагууд болон сумдын ЗДТГ-аас санал авсны дагуу Хэнтий аймгийн 2020 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөг батлан Удирдлагын академи, Төрийн албаны зөвлөл, холбогдох төрийн захиргааны төв байгууллага, төрийн бус байгууллагуудтай хамтран төрийн албан хаагчдыг чадавхжуулах сургалтын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажилласан.

7. Сургалт судалгаа, сурталчилгаа хийх хүрээнд:

7.1. Төрийн албаны зөвлөлөөс баталсан хөтөлбөр, удирдамжийн дагуу сургалт, сурталчилгаа зохион байгуулах;

Сургалтын нэгдсэн төлөвлөгөө боловсруулж, 82 төрлийн сургалт зохион байгуулахаар төлөвлөснөөс COVID-19 цар тахалтай холбогдуулан хязгаарлалтын дэглэмд 53 төрлийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 11.772 төрийн албан хаагчдыг сургалтад хамруулсан байна.

Төрийн албаны цалингийн нэгдсэн системд хамрагдах 177 төсөвт байгууллагын нягтлан бодогч нарт 6 дугаар сарын 8-10, 15-17-ны өдрүүдэд 2 удаагийн сургалт зохион байгуулж тус системийг хэрэгжүүлэх ажлыг бүрэн нэвтрүүлсэн. Сургалтын төлөвлөгөө, сургалтад хамрагдсан нягтлан бодогчдын бүртгэл, тайланг гарган Сангийн яамны төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн нэгжид хүргүүлсэн.

2020 оны 9 дүгээр сараас аймгийн төвийн бүх байгууллага, 10 дугаар сараас сумын төсөвт байгууллагууд цалингийн нэгдсэн системийг бүрэн нэвтрүүлж төрийн сангаар гүйлгээгээ хийн ажиллаж байна.





“Төрийн байгууллагын стратеги төлөвлөлт хийх арга зүй” сэдэвт ажлын байран дахь сургалтыг Төрийн албаны зөвлөлийн НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэй хэрэгжүүлж буй “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төсөл, Удирдлагын академитай хамтран 41 төрийн албан хаагчдыг хамруулан зохион байгуулсан.




Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх багц сургалтад эрхэлсэн түшмэлийн багц сургалтад 2, ахлах түшмэлийн багц сургалтад 57, мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 12, мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 12, чиглүүлэх сургалтад 17, зорилтод богино хугацааны сургалтад 58, нийт 158 албан хаагчийг хамруулсан.

7.2. Төрийн албаны шинэтгэл, Төрийн албаны тухай хууль тогтоомж, бодлого, үзэл баримтлалыг төрийн албан хаагч болон олон нийтэд танилцуулах, сурталчлах;

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн шийдвэр, төрийн албаны мэргэшлийн шалгалт, удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалттай холбоотой бусад мэдээ мэдээллийн талаар мэдээллийн самбарт болон www.khentii.mn цахим хуудсанд байршуулан сурталчлах ажлыг тогтмолжуулаад байна.



Мөн цаг үеийн мэдээ, мэдээллийг тухай бүр нь Хэнтий аймаг Миний нутаг хуудсаар болон хандалт ихтэй сошиал зарын бүлгэмүүдэд дамжуулан мэдээлэн ажиллаж байна.





7.3. Төрийн алба, төрийн албан хаагчийн талаар судалгаа хийх;

Төрийн албан хаагчидтай холбоотой мэргэшүүлэх багц сургалтын, хүний нөөцийн, түр орлон гүйцэтгэгчийн, сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга нарын, сул орон тооны гэх мэт судалгааг цаг тухай бүр нь хийж, нэгтгэн Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академид хүргүүлэн ажилласан.

Мөн шаардлагатай мэргэжилтний судалгааг хийж орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн чухал салбарууд дахь дутагдалтай хүний нөөцийг бүрдүүлэх, сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэх, орон нутагтаа тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллаж байгаа иргэдийг хилийн чанадад сурах, мэргэжлээ дээшлүүлэх, мэргэшихэд дэмжлэг үзүүлэх, орон нутгийнхаа хөгжил дэвшилд хувь нэмэр оруулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор "Мэргэжилтэй ажилтан бэлтгэх, хүний нөөцийг бүрдүүлэх" журмын төслийг боловсруулж, аймгийн ИТХ-аар батлуулахаар ажиллаж байна.

7.4. Орон нутгийн төсвийн удирдлагын зардлын төслийг боловсруулах, хянаж батлахад санал гаргах;

2020 оны орон нутгийн төсөвт Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардалд 6,0 сая төгрөгийг аймгийн ЗДТГ-ын төсвийн багцад суулгуулсан.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн сургалтын танхимтай болохоор өрөө танхим, техник, хэрэгслийн асуудлыг шийдвэрлэж тохижуулах ажлыг эхлүүлээд байна.

Тус танхимд төрийн албаны тусгай шалгалт болон төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалт, сургалт, сурталчилгааны ажлуудыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

8. Хүний нөөцийн бодлогын хүрээнд:

8.1. Төрийн алба, төрийн албан хаагчийн талаарх мэдээ мэдээлэл, материал, судалгааг харьяалах байгууллагаас гаргуулж авах;

Төрийн албан хаагчдын мэргэшүүлэх /давтан болон чиглүүлэх/ багц сургалтын, Тэргүүн, эрхэлсэн, ахлах түшмэлийн албан тушаалын ангилалд хамаарах албан хаагчийн нөөцийн, ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүний, төсвийн байгууллагуудын бүтэц, орон тоо, 2018-2020 оны төсвийн орлого, зарлагын, сул орон тооны, сургалтад хамрагдсан тухай, нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардлын судалгаа, зөрчилтэй томилгооны судалгаа гэх мэт судалгааг харьяалах байгууллагаас гаргуулж, нэгтгэн

Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академид цаг хугацаанд нь хүргүүлж ажиллав.

Төрийн албан хаагчдын судалгааны нэгдсэн сан үүсгэсэн.

8.2. Төрийн захиргааны албан хаагчид зэрэг дэв шинээр болон ахиулан олгох санал гаргах;

Төрийн захиргааны албан хаагчид зэрэг дэв шинээр олгох 38, 65 албан хаагчид ахиулан олгох санал гаргаж, аймгийн Засаг даргад өргөн мэдүүлж, аймгийн Засаг даргын 2020 оны Б/10 дугаар захирамжаар нийт 103 албан хаагчид зэрэг дэв олгосон шийдвэрийг гаргуулсан.

8.3. Төрийн албан хаагчийг холбогдох журамд заасны дагуу шагнаж урамшуулах санал гаргах;

Монгол Улсын Төрийн дээд одон медальд нийт 65 төрийн албан хаагчийг өргөн мэдүүлсэн. Үүнд: “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-оор 1, Алтан гадас одонгоор- 16, Хөдөлмөрийн хүндэт медалиар- 48

Мөн “Төрийн албаны тэргүүний ажилтан цол тэмдэг”-ээр шагнуулахаар төрийн албанд олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга С.Нямдаваа, мэргэжилтэн С.Энхтоогоо нарыг нэр дэвшүүлсэн.

8.4. Төрийн албаны зөвлөлөөс албан тушаалын тодорхойлолт хянах чиглэлээр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх;

Аймгийн ИТХ-ын ажлын алба, Засаг даргын Тамгын газар болон нийт 10 байгууллагын төрийн захиргааны 123 албан тушаалд хамаарах 83 албан тушаалын тодорхойлолтыг журмын дагуу боловсруулан Төрийн албаны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлах зөвшөөрөл олгосны дагуу байгууллагын даргын тушаалаар баталсан.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 3 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 5.3-ын дагуу төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн албан тушаалын тодорхойлолтод санал авахаар албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2019 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 42 дугаар албан бичгээр хүргүүлж санал авсны дагуу албан тушаалын тодорхойлолтыг холбогдох хууль, журмын дагуу томилох эрх бүхий албан тушаалтан шийдвэр гарган баталсан. Үүнд: Ардын дуу бүжгийн Хан Хэнтий чуулгын дарга, Нийтийн номын сангийн захирал, Музейн захирал, Нэгдсэн эмнэлгийн дарга, Уламжлалт анагаах ухааны төвийн захирал, Ерөнхий боловсролын сургуулийн захирал, Цэцэрлэгийн эрхлэгч, сумын Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн эрхлэгч нарын албан тушаалын тодорхойлолтыг тус тус батлуулсан.

ГУРАВ. БУСАД ХЭСЭГ

Орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн чухал салбарууд дахь дутагдалтай хүний нөөцийг бүрдүүлэх, сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэх, орон нутагтаа тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллаж байгаа иргэдийг хилийн чанадад сурах, мэргэжлээ дээшлүүлэх, мэргэшихэд дэмжлэг үзүүлэх, орон нутгийнхаа хөгжил дэвшилд хувь нэмэр оруулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор **"Мэргэжилтэй ажилтан бэлтгэх, хүний нөөцийг бүрдүүлэх"** журмын төслийг боловсруулж, аймгийн ИТХ-аар батлуулахаар ажиллаж байна.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд үйлчилгээ үзүүлж буй албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлж иргэдэд төрийн үйлчилгээг чирэгдэлгүй шуурхай хүргэх үүднээс 2019 оны 4 дүгээр сард албан хаагч тус бүрд үнэлгээний төхөөрөмж, дуу, дүрсний камер

байрлуулснаар 2019, 2020 онд эдгээр албан хаагчидтай холбоотой гомдол ирээгүй бөгөөд үйл ажиллагааг нь иргэд үнэлж хэвшсэн.

Хэнтий аймагт үйл ажиллагаа явуулж буй 185 төрийн байгууллагын өргөдөл гомдлын хяналтын нэгдсэн системийг нэвтрүүлснээр шийдвэрлэлт 87 хувиас 97 хувь болж өссөн.

Төр иргэдийн уялдаа холбоог сайжруулах, мэдээ, мэдээллийг түргэн шуурхай үнэн бодитоор хүргэх, солилцох, иргэдийг аливаа үйл ажиллагаанд оролцох идэвх санаачлагыг нэмэгдүүлэх, орон нутагт тулгамддаг асуудлуудыг хамтдаа шийдвэрлэх зорилгоор аймгийн ЗДТГ, Тогтвортой амьжиргаа-3 төсөлтэй хамтран “Иргэдийн оролцоотой шинэ Хэнтий” төслийг 2019 онд анх удаа санаачлан хэрэгжүүлж, айл өрхүүдийг **791** аравт, хэсэг, бүлгийн зохион байгуулалтад оруулснаар иргэдийн оролцоо 34 хувиас 75 хувь болж өссөн.

Аймгийн Засаг дарга, ЗДТГ нь иргэдээс өргөдөл гомдол, санал хүсэлтийг цахимаар, иргэдээ сонсьё 70563111 утсаар, саналын хайрцгаар, амаар болон бичгээр гэсэн боломжит бүхий л хэлбэрээр хүлээн авч байгаа бөгөөд эдгээр сувгуудын тухай богино хэмжээний шторк бэлтгэн орон нутгийн телевиз, цахим хаягаар сурталчлан ажилласан. Мөн иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын тайланг Khentii.mn сайт болон олон нийт мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд мэдээлдэг.

2020 онд аймгийн Засаг дарга болон түүний Тамгын газарт нийт 294 өргөдөл ирсэн байна. Үүнээс 214 нь бичгээр 83 нь аймгийн Засаг даргын иргэдтэй уулзах цагаар биечлэн уулзаж санал хүсэлтээ илэрхийлсэн.

2020 онд аймгийн хэмжээнд жендэрийн чиглэлээр 8 удаагийн сургалтыг Хэрлэн, Биндэр, Мөрөн, Өмнөдэлгэр сумдад зохион байгуулж, нийт 193 албан хаагч, мэргэжилтнийг хамруулсан. Үүнд: аймгийн Салбар хорооноос сум болон байгууллагын удирдлага 45 албан хаагчдыг хамруулан жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль, хөтөлбөрийг орон нутагт хэрхэн хэрэгжүүлэх, харьяа сумын байгууллага, аж ахуйн нэгжийн Хөдөлмөрийн дотоод журамд жендэрт суурилсан хүчирхийлэл, ажлын байрны бэлгийн дарамтаас сэргийлэх талаар тусгах сэдвээр сургалт зохион байгуулж, албан тоотоор чиглэл хүргүүлэн ажилласан. Хамрагдсан албан хаагчид 100% удирдах албан тушаалтан бөгөөд 31 эрэгтэй, 14 эмэгтэй байна. Сургалтын үр дүнд 58 байгууллага Хөдөлмөрийн дотоод журамдаа тус агуулгыг тусган ажиллаж байна.

Хэнтий аймгийн 185 байгууллагын 4684 албан хаагчдын 3085 эмэгтэй, 1599 эрэгтэй албан хаагч байна. Төрийн байгууллагын удирдах албан тушаалтны судалгаанаас үзэхэд төрийн улс төрийн удирдах албан тушаалтан 125, үүнээс эмэгтэй 35 буюу 28 хувь, төрийн захиргааны удирдах албан тушаалтан 126, үүнээс эмэгтэй 62 буюу 49,2 хувь, төрийн тусгай удирдах албан тушаалтан 29, үүнээс эмэгтэй 1 буюу 3,4 хувь, төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтан 227, үүнээс эмэгтэй 172 буюу 75,8 хувьтай байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Төрийн албаны зөвлөлийн Хэнтий аймаг дахь салбар зөвлөл нь 2020 онд 21 арга хэмжээг төлөвлөснөөс 100 хувь биелж, төлөвлөсөн ажлаа амжилттай хэрэгжүүлж ажилласан.

2019 оны хувьд Төрийн албаны тухай хууль /шинэчлэн найруулсан/, дүрэм, журам шинэчлэгдэж гарч байсан тул сул орон тоог нөхөх, сонгон шалгаруулалтыг явуулах боломжгүй байсан бол 2020 онд ковид 19 цар тахал гарсан хэдий ч мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу төрийн албаны ерөнхий, тусгай шалгалт, сонгон шалгаруулалтыг тасралтгүй зохион байгуулж ажиллалаа.

2020 оны хувьд сургалт, арга зүйн зөвлөмжийг зохион байгуулан явуулахад хязгаарлагдмал нөхцөл байдал үүссэн хэдий ч техник технологийн дэвшлийг ашиглан цахимаар хурал, уулзалт, сургалтыг зохион байгуулж төрийн албан хаагчдыг чадавхжуулах, мэргэшүүлэх зорилтоо амжилттай хэрэгжүүллээ.

№	Үйл ажиллагааны төрөл	2019 онд	2020 онд
1.	Хуралдааны тоо	8	12
2.	Хэлэлцсэн асуудлын тоо	22	37
3.	Төрийн албаны ерөнхий шалгалтад тэнцэж, төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдсэн иргэний тоо	17	34
4.	Төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалт зохион байгуулсан тоо	0	4
5.	Төрийн албаны тусгай шалгалт зохион байгуулсан тоо	0	7
6.	Нөхөгдсөн сул орон тоо	0	41
7.	Ёс зүйн зөрчлийн тоо	ТЗ-9 ТҮ-9 ТТ-мэдээнд аваагүй	ТЗ-0 ТҮ-18 ТТ-9
8.	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд ирсэн өргөдөл, гомдлын тоо	14	11

ТАВ. САНАЛ

1. Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.3. дахь хэсэгт заасны дагуу аймаг, нийслэлийн салбар зөвлөлүүдийн хараат бус, бие даасан байдлыг хангах, 66 дугаар зүйлийн 66.1. дэх хэсэгт заасан бүрэн эрхийг төлөөлөн хэрэгжүүлэх боломжийг хангахын тулд бие даасан нэгж хэлбэрээр орон тооны дарга, нарийн бичгийн даргатайгаар ажиллуулах,

2. Төрийн албаны ерөнхий шалгалтыг улирал тутам зохион байгуулж байх

3. Төрийн албаны зөвлөлийн дэргэд сургалтын байгууллагатай болох,

4. Төрийн албаны ерөнхий шалгалт өгч эхний 1-2 шалгалтад босго оноог даваад дараагийн шалгалтуудад босго оноог давж чадаагүй тохиолдолд тухайн иргэнийг дахин зарлагдах Төрийн албаны ерөнхий шалгалтад босго оноог давсан шалгалтыг тооцож, унасан шалгалтуудыг өгөх боломжийг хангах,

5. Туслах түшмэлийн ангиллын албан тушаалд томилогдох иргэнийг албан тушаалын тусгай шаардлагыг хангаж байгаа тохиолдолд Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн шийдвэрээр төрийн албаны тусгай шалгалтгүйгээр төрийн жинхэнэ албаны нөөцөөс нэр дэвшүүлэн томилох,

6. Төрийн захиргааны удирдах албан тушаалын сонгон шалгаруулалтыг босго оноотой болгох /нийт дүнгээр босго заах/,

7. Байгууллага, нэгж дотор, нэгжээс нэгжийн хооронд шилжүүлэн томилох тохиолдолд зохицуулалт байхгүй байгааг шийдвэрлэх,

8. Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журмын 2.5.4-т заасныг зөвхөн 50 хувийг хангаж байгаа албан хаагч гэж хязгаарлахгүйгээр нийт шатлан дэвших албан хаагчид тавих шаардлага болгож оруулах, мөн өөр байгууллагаас шатлан дэвшүүлэх тохиолдолд энэхүү заалтыг хэрхэн шийдвэрлэх талаар тодорхой болгох,

9. Төрийн албан хаагчдын ёс зүйн дүрэмд хариуцлага хүлээлгэх уучлал гуйхыг үүрэг болгох, сануулах гэсэн 2 хариуцлага хүлээхээр заасан. Үүнийг Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан арга хэмжээгээр хариуцлага хүлээлгэх.

ТАЙЛАН ХЯНАСАН:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ж.ГАНБААТАР

ТАЙЛАН ГАРГАСАН:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Ж.САРУУЛТӨГС

**Төрийн албаны зөвлөлийн Хэнтий аймаг дахь салбар зөвлөлөөс гарсан
шийдвэрийн хэрэгжилтийг тооцсон байдал**

№	Төрийн албаны зөвлөлийн Хэнтий аймаг дахь салбар зөвлөлөөс гарсан тогтоолын			Тогтоолын хэрэгжилт
	Утга	Огноо	№	
1.	Санал уламжлах тухай	2020.03.27.	01	Аймгийн Засаг даргын 2020 оны Б/10 дугаар захирамжаар 103 төрийн захиргааны албан хаагчид зэрэг дэв олгох, ахиулах шийдвэр гарсан.
2.	Шагналд тодорхойлох тухай	2020.03.27.	02	Төрийн албаны зөвлөлд албан бичгээр шагналын материалыг хүргүүлсэн.
3.	Зөвлөл байгуулах тухай	2020.04.24.	03	Нийт 5 удаагийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулахад мэргэжлийн чиг үүргийн дагуу дэмжлэг үзүүлэн ажилласан.
4.	Сонгон шалгаруулалтын комисс байгуулах тухай	2020.04.28.	04	2020 оны 5 дугаар сарын 05-ны өдөр сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан.
5.	Шалгалтын комисс байгуулах тухай	2020.04.28.	05	2020 оны 5 дугаар сарын 05-ны өдөр тусгай шалгалтыг зохион байгуулсан.
6.	Нэгдсэн эмнэлгийн даргын албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.05.05.	06	Нэгдсэн эмнэлгийн эмч, ажиллагсдаас сонгон шалгаруулалттай холбоотой гомдол гарсан тул гомдлыг шийдвэрлэх хүртэлх хугацаанд түдгэлзүүлсэн.
7.	Галшар сумын ЗДТГ-ын даргын албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.05.05.	07	Галшар сумын Засаг даргын 2020 оны Б/06 дугаар захирамжаар Ш.Цэвэлсүрэнг сумын ЗДТГ-ын даргын албан тушаалд томилсон.
8.	Баянхутаг сумын ЗДТГ-ын Санхүүгийн албаны даргын албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.05.05.	08	Төсвийн тухай хуулийн дагуу аймгийн Засаг даргатай зөвшилцөх саналын хариуг хүлээж буй тул томилох шийдвэр гараагүй байна.
9.	Шалгалтын комисс байгуулах тухай	2020.05.18.	09	2020 оны 5 дугаар сарын 22-ны өдөр тусгай шалгалтыг зохион байгуулсан.
10.	Гомдлын дагуу тодруулга өгөх ажлын хэсэг байгуулах тухай	2020.05.18.	10	2020 оны 50 тоот албан бичгээр тодруулгыг хүргүүлсэн.
11.	Сонгон шалгаруулалтын комисс байгуулах тухай	2020.05.20.	11	2020 оны 5 дугаар сарын 26-ны өдөр сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан.
12.	Баян-Адарга сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.05.25.	12	С.Энхцэцэг нь Баян-Адарга сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдохоос татгалзсан.
13.	Баян-Адарга сумын ЗДТГ-ын даргын албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.05.25.	13	Баян-Адарга сумын Засаг даргын 2020 оны А/47 захирамжаар Ч.Эрдэнэ-Очирыг сумын ЗДТГ-ын даргын албан тушаалд томилсон.
14.	Хүнс, хөдөө аж ахуйн газрын Захиргаа, аж ахуйн албаны даргын албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.05.25.	14	Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын 2020 оны Б/13 дугаар тушаалаар Б.Саранцэцэгийг Захиргаа, аж ахуйн албаны даргын албан тушаалд томилсон.

15.	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтний албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.05.25.	15	Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын 2020 оны Б/53 дугаар тушаалаар Ж.Ганбаярыг Хууль, эрх зүйн хэлтсийн Эрх зүйн сургалт, сурталчилгаа, хүний эрх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалд томилсон.
16.	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтний албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.05.25.	16	Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын 2020 оны Б/54 дүгээр тушаалаар С.Лхагвачулууныг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Дэд бүтэц, төлөвлөлтийн бодлого хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилсон.
17.	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтний албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.05.25.	17	Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын 2020 оны Б/53 дугаар тушаалаар Б.Хуланг Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төсөвт байгууллагын төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилсон.
18.	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтний албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.05.25.	18	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын 2020 оны Б/51 дүгээр тушаалаар Г.Чулуунсайханыг Баян-Адарга сумын Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилсон.
19.	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтний албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.05.25.	19	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын 2020 оны Б/52 дугаар тушаалаар Т.Сүрэнцэцэгийг Баян-Адарга сумын Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилсон.
20.	Шалгалтын комисс байгуулах тухай	2020.05.25.	20	2020 оны 5 дугаар сарын 29-ний өдөр тусгай шалгалтыг зохион байгуулсан.
21.	Нийгмийн даатгалын хэлтсийн Галшар сумын Нийгмийн даатгалын байцаагчийн албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.06.02.	21	Нийгмийн даатгалын хэлтсийн даргын 2020 оны Б/33 тушаалаар Д.Төгсжаргалыг Галшар сумын Нийгмийн даатгалын байцаагчийн албан тушаалд томилсон.
22.	Шалгалтын комисс байгуулах тухай	2020.06.02.	22	2020 оны 6 дугаар сарын 08-ны өдөр тусгай шалгалтыг зохион байгуулсан.
23.	Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын Хүнс, жижиг, дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.06.10.	23	Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны Б/42 дугаар тушаалаар Т.Эрдэнэцэцэгийг Хүнс, жижиг, дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилсон.
24.	Дадал сумын Засаг даргын Тамгын газрын Хүнс, жижиг,	2020.06.10.	24	Дадал сумын ЗДТГ-ын даргын 2020.07.07 Б/16 дугаар тушаалаар Э.Баасанхүүг Хүнс,

	дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд нэр дэвшүүлэх тухай			жигжиг, дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилсон.
25.	Биндэр сумын Засаг даргын Тамгын газрын Төсөв, төрийн сангийн мэргэжилтний албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.06.10.	25	Биндэр сумын ЗДТГ-ын даргын 2020.06.22-ны Б/22 дугаар тушаалаар А.Мишээлтийг Төсөв, төрийн сангийн мэргэжилтний албан тушаалд томилсон.
26.	Бор-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын Төсөв, төрийн сангийн мэргэжилтний албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.06.10.	26	Бор-Өндөр сумын ЗДТГ-ын даргын 2020.07.01. Б/25 дугаар тушаалаар Б.Оюунтуяаг Төсөв, төрийн сангийн мэргэжилтний албан тушаалд томилсон.
27.	Батширээт сумын байгаль хамгаалагчийн албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.06.10.	27	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын 2020 оны Б/33 дугаар тушаалаар Б.Болдыг Батширээт сумын байгаль хамгаалагчийн албан тушаалд томилсон.
28.	Биндэр сумын байгаль хамгаалагчийн албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.06.10.	28	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын 2020 оны Б/34 дүгээр тушаалаар Н.Болор-Эрдэнийг Биндэр сумын байгаль хамгаалагчийн албан тушаалд томилсон.
29.	Биндэр сумын байгаль хамгаалагчийн албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.06.10.	29	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын 2020 оны Б/32 дугаар тушаалаар А.Гэрэлмааг Биндэр сумын байгаль хамгаалагчийн албан тушаалд томилсон.
30.	Шалгалтын комисс байгуулах тухай	2020.06.16.	30	2020 оны 6 дугаар сарын 17-ны өдөр тусгай шалгалтыг зохион байгуулсан.
31.	Шалгалтын комисс байгуулах тухай	2020.06.17.	31	2020 оны 6 дугаар сарын 22-ны өдөр тусгай шалгалтыг зохион байгуулсан.
32.	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Аялал жуулчлалын албаны даргын албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.06.23.	32	БОАЖГ-ын даргын 2020.07.01. Б/36 дугаар тушаалаар Б.Баясгаланг Аялал жуулчлалын албаны даргын албан тушаалд томилсон.
33.	Мэргэжлийн хяналтын газрын Таримал ургамлын үр, хорио цээрийн хяналтын улсын байцаагчийн албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.06.23.	33	МХГ-ын даргын 2020.10.23. Б/43 дугаар тушаалаар Г.Одбаярыг Таримал ургамлын үр, хорио цээрийн хяналтын улсын байцаагчийн албан тушаалд томилсон.
34.	Сонгон шалгаруулалт зохион байгуулах комисс байгуулах тухай	2020.09.14.	34	2020 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагчийн 22 сул орон тооны сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан.
35.	Ардын дуу бүжгийн хан Хэнтий чуулгын даргын албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.09.21.	35	Одоогоор хариу ирүүлээгүй томилох асуудлыг түр хугацаагаар хойшлуулсан талаар амаар мэдэгдсэн.
36.	Бор-Өндөр сумын 1 дүгээр цэцэрлэгийн эрхлэгчийн	2020.09.21.	36	Бор-Өндөр сумын Засаг даргын 2020.11.04. Б/22 дугаар захирамжаар П.Адилжаргалыг

	албан тушаалд нэр дэвшүүлэх тухай			Бор-Өндөр сумын 1 дүгээр цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалд томилсон.
37.	Бор-Өндөр сумын 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.09.21.	37	Бор-Өндөр сумын Засаг даргын 2020.11.04. Б/21 дүгээр захирамжаар Д.Гэрэлмааг Бор-Өндөр сумын 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалд томилсон.
38.	Баян-Адарга сумын цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.09.21.	38	Баян-Адарга сумын Засаг даргын 2020.12.01. Б/21 дүгээр захирамжаар С.Өнөрцэцэгийг Баян-Адарга сумын цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалд томилсон.
39.	Баян-Овоо сумын цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.09.21.	39	Баян-Овоо сумын Засаг даргын 2020.10.29. Б/24 дүгээр захирамжаар Ц.Энхмааг Баян-Овоо сумын цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалд томилсон.
40.	Галшар сумын цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.09.21.	40	Галшар сумын Засаг даргын 2020.10.28. Б/20 дугаар захирамжаар Ж.Хонгорзулыг Галшар сумын цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалд томилсон.
41.	Хэрлэн сумын 2 дугаар цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.09.21.	41	Хэрлэн сумын Засаг даргын 2020.10.12. Б/27 дугаар захирамжаар Ш.Оюунжаргалыг Хэрлэн сумын 2 дугаар цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалд томилсон.
42.	Хэрлэн сумын Яслийн эрхлэгчийн албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.09.21.	42	Хэрлэн сумын Засаг даргын 2020.10.12. Б/28 дугаар захирамжаар Д.Золзаяаг Хэрлэн сумын Яслийн эрхлэгчийн албан тушаалд томилсон.
43.	Баян-Адарга сумын Соёлын төвийн эрхлэгчийн албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.09.21.	43	Баян-Адарга сумын Засаг даргын 2020.12.01. Б/20 дугаар захирамжаар Ө.Гантогоог Баян-Адарга сумын Соёлын төвийн эрхлэгчийн албан тушаалд томилсон.
44.	Бор-Өндөр сумын Соёлын төвийн эрхлэгчийн албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.09.21.	44	Бор-өндөр сумын Засаг дарга томилохоос татгалзсан.
45.	Батноров сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.09.21.	45	Батноров сумын Засаг даргын 2020.10.02-ны 192 тоот албан бичгээр томилохоос татгалзсан.
46.	Баян-Адарга сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.09.21.	46	Баян-Адарга сумын Засаг даргын 2020.12.01. Б/19 дүгээр захирамжаар Ж.Батсүрэнг Баян-Адарга сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн албан тушаалд томилсон.
47.	Баянмөнх сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.09.21.	47	Баянмөнх сумын Засаг даргын 2020.12.01. Б/15 дугаар захирамжаар С.Нансалыг Баянмөнх сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн албан тушаалд томилсон.

48.	Баянхутаг сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.09.21.	47	Баянхутаг сумын Засаг даргын 2020.12.03. Б/21 дүгээр захирамжаар Г.Энхсайханыг Баянхутаг сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн албан тушаалд томилсон.
49.	Салбар комисс байгуулах тухай	2020.10.08.	49	Төрийн албаны ерөнхий шалгалтыг 2020 оны 11 дүгээр сарын 06-08-ны өдрүүдэд зохион байгуулсан. Төрийн албаны ерөнхий шалгалтад 324 иргэн бүртгүүлж, 226 иргэн шалгалтад орсноос ерөнхий мэдлэгийн шалгалтад 45, монгол хэл, бичгийн шалгалтад 34, дүн шинжилгээ хийх чадварын шалгалтад 32 иргэн тус тус тэнцэж, төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдсэн.
50.	Сонгон шалгаруулалт зохион байгуулах комисс байгуулах тухай	2020.12.04.	50	2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагчийн 8 сул орон тоонд сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан.
51.	Шалгалтын комисс байгуулах тухай	2020.12.04.	51	2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 6 сул орон тоонд төрийн албаны тусгай шалгалтыг зохион байгуулсан.
52.	Уламжлалт анагаах ухааны эмнэлгийн даргын албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.12.11.	52	ЭМГ-ын даргын 2020.12.22. А/45 дугаар тушаалаар М.Давааг Уламжлалт анагаах ухааны эмнэлгийн даргын албан тушаалд томилсон.
53.	Дэлгэрхаан сумын Соёлын төвийн эрхлэгчийн албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.12.11.	53	Ж.Наранчимэг нь Дэлгэрхаан сумын Соёлын төвийн эрхлэгчийн албан тушаалд томилогдохоос татгалзсан.
54.	Орон нутгийн өмчийн газрын даргын албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.12.11.	54	Аймгийн Засаг даргын 2020.12.16-ны Б/80 дугаар захирамжаар Л.Батсайханыг Орон нутгийн өмчийн газрын даргын албан тушаалд томилсон.
55.	Цэнхэрмандал сумын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны даргын албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.12.11.	55	Сумын Засаг даргын 2021.01.11-ний Б/06 дугаар захирамжаар Г.Болор-Эрдэнийг Цэнхэрмандал сумын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны даргын албан тушаалд томилсон.
56.	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтний албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.12.11.	56	Аймгийн ЗДТГ-ын даргын 2020.12.23. Б/104 дүгээр тушаалаар Д.Бадамцэцэгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төсөвт байгууллагын төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилсон.
57.	Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын Төсөв, төрийн сангийн мэргэжилтний албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	2020.12.11.	57	Сумын ЗДТГ-ын даргын 2020.12.24-ний Б/43 дугаар тушаалаар Г.Дашмааг Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын Төсөв, төрийн сангийн мэргэжилтний албан тушаалд томилсон.